



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, 15,972,370.00 /арван таван сая есөн зуун далан хоёр мянга гурван зуун далан/ төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 1 ширхэг автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал Д.Должинд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

D:\Huraldaanii material\2021 on\2021.01.12 1r huraldaan.docx

13201767

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн
22... дугаар тогтоолын хавсралт

Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	УАЗ-22069, 50-45 ДОА, арал №50447923	2005/ 2005	15,972,370.00
	Нийт дүн		15,972,370.00 /арван таван сая есөн зуун далан хоёр мянга гурван зуун далан/